

14 ХОНОГИЙН ШУУРХАЙ МЭДЭЭ

2021.06.25

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны 06 дугаар сарын 21-ны өдөр сумын онцгой комиссын 14-р зохион байгуулж, суманд илэрсэн сэжигтэй тохиолдлын ойрын хавтлыг тодорхойлох ажлыг зохион байгуулж, Сумын засаг даргын захирамжаар 72 цагийн 00 зогсолтыг хийлээ.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны 06 дугаар сарын 24-ны өдөр сумын онцгой комиссын 15-р хуралдааныг зохион байгуулж, 72 цагийн 00 зогсолтыг цуцалж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх талаар хэлэлцэн шийдвэрлэж, Сумын засаг даргын захирамжаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байна.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан төрийн байгууллагын албан хаагчид 12-24 цагийн ээлжээр эргүүл хяналтын постонд ажиллаж байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх гудамжны цамхагт гэрэлтүүлэг, баяндалай гудамжны гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн хашааны засварын бүлэг сонгон шалгаруулалтыг орон нутгийн хөгжлийн сангийн бүрэлдэхүүнээр хуралдан шийдвэрлэж, сумын засаг даргын захирамжийг үндэслэн гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх гүн өрмийн худаг, цооног өрөмдөх, хүүхдийн тоглоомын талбайн завсар, өвс фондны хашааны засварын тендэр сонгон шалгаруулалтыг зарлалаа.

Нийгмийн бодлогын хүрээнд: Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан гэрээийг 56 заалтын хэрэгжилтийг гарган холбогдох газарт хүргүүлэв.

Хүүхэд гэр бүл, хөгжлийн газраас зохион байгуулсан эрсдэлтэй орчинд амьдарч буй хүүхдүүдэд кейс ажиллах ажлын хүрээнд сумын хэмжээнд эрсдэлтэй орчинд амьдарч буй хүүхдийн судалгааг гарган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас баталсан суманд холбогдолтой үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг гарган холбогдох газарт хүргүүллээ.

Сумын ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтын хүрээнд www.dundgovi.gov.mn сайтад төрийн байгууллагын ил тод байдал, албан хаагчдын танилцуулга, цаг үеийн мэдээ, мэдээллийн байрлуулж, төрийн байгууллагын олон нийтэд ил тод нээлттэй байдлыг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Байгаль орчны хяналт шалгалтын хүрээнд: Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч ЧинХаш ХХК нь ашигт малтмал газрын тосны газраас олгосон зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн

хашаа, барилга байгууламж барьсан гэх гомдол мэдээллийг бүртгэн хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Тус хяналт шалгалтаар ЧинХаш ХХК нь шав тэмдэг тэмдэглэгээг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн ашигласан зөрчил байгаагүй тул гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан тогтоолыг үйлдэж хаасан.

2021 оны 04-р сарын 08-ны өдөр говь-Угтаал сумын 2-р багийн нутаг Хадмал нэртэй газарт байгалийн өнгөт чулууг хууль бусаар түүсэн, тээвэрлэсэн гэх гомдол мэдээллийг Аймгийн цагдаагийн газарт шилжүүлэн шалгуулсан боловч холбогдогч нас барсан тул гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзан тогтоол үйлдэн хаав.

Ерөнхий боловсролын чиглэлээр:

Ерөнхий боловсролын сургуулийн захирал, нягтлан бодогч боловсрол соёл урлагын газраас зохион байгуулсан цахим сургалтанд оролцлоо.

2021 оны 06-р сарын 25-ны өдөр сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сургалтын менежер Авлигын эсрэг цахим сургалтанд оролцлоо.

Хөдөө, аж ахуйн чиглэлээр:

7 хоног бүр тогтмол гаргадаг хүнс, малын зүй бус хорогдол, отор, өвс тэжээлийн нөөцийн мэдээг холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа

Сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийг монголбанкны зээлийн мэдээллийн санд цаг хугацаанд нь холбогдож бүрэн шинчлэл хийлгэж сангийн мэдээлэл дамжуулан ажиллалаа.

Зах зээл бэлчээр удирдлага төслөөс Хаан банктай хамтран хэрэгжүүлж байгаа зээлийн мэдээллийг иргэдэд хүргэж 1 аж ахуй нэгж, 12 иргэнийг банктай холбон ажиллаж байна.

Ургамал судлалийн хүрээлэнд орон нутгийн бэлчээрийн талхлалт болон бэлчээрийн даац хэтрэлтийн мэдээллийн цаг уурын байгууллага, багийн дарга нартай хамтран гаргаж ажиллалаа.

Эрүүл мэндийн төв: Коронавирусээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакинжуулалтанд жирэмсэн, хөхүүл, архаг хууч өвчтэй иргэдэд зориулсан Америк улсын файзер нэртэй вакциний 60 тунг хийж дуусгалаа.

Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан цахим хуралдаанд эмч эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдлаа. Сумын эрүүл мэндийн төвийн их эмч Г.Угтахбаяр Эрдэнэдалай сумын эмнэлэгт коронавирусээр өвчилсөн иргэдийг эмчлэхээр дайчлагдан ажиллаж байна. "Коронавирусийн эсрэг эмчилгээнд кагоцел вирусийн эмийн үр нөлөө" сэдэвт цахим сургалтанд эмч нар хамрагдаж мэдлэгээ дээшлүүллээ.

Дараа долоо хоногийн ажил

12-16 нас хүртэлх хүүхдүүдийн коронавирусээс урьдчилан сэргийлэх вакцинийг хийхээр бэлтгэл ажлаа хангаж байна.

Эмнэлгийн тохижилт үйлчилгээнд анхаарч, гадаа хашааны төмрийг будгаар будахаар бэлдэж байна.

Хүүхдийн цэцэрлэг: Байгууллагын албан хаагчид 2020-2021 оны хичээлийн жилийн тайлангаа танилцуулж, Эрхлэгч А.Алтанчимэг 2020-2021 оны хичээлийн жилийн тайлангаа БСУГ-т танилцууллаа.

Байгууллагын гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 108 мод суулгаж 8 түмэн мод аянд нэгдлээ.

2021 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллого 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдан байгууллагын эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг зохион байгууллаа.

Байгууллагын 6 албан хаагчид төсөлт тоглоомын аргазүй сэдэвт цахим сургалтанд оролцлоо. Ерөнхий боловсролын монгол хэл, уран зохиолын багшаар 48 цагийн монгол бичгийн сургалтанд хамрагдаж, батламжаа гардан авлаа.

ТАЙЛАН БИЧСЭН

АРХИВ,БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Г.АМАРБАЯР

ХЯНАСАН

ЗДТГАЗРЫН ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ